



**УЛСЫН НЭГДҮГЭЭР
ТӨВ ЭМНЭЛЭГ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
С.Зоригийн гудамж-2, Утас: +976-77111027
И-мэйл: info@fchm.edu.mn

2024.11.29 № 11876
танай 2024.11.19-ны № 211828 -Т

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ
УДИРДЛАГЫН ГАЗАРТ

Тайлан хүргүүлэх тухай

2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 2/4828 тоот албан бичгийн дагуу Эрүүл мэндийн сайдын баталсан “Эрүүл мэндийн салбар дахь Хүний эрхийг хамгаалах чиглэлээр хэрэгжүүлэх 2024 оны төлөвлөгөө”-ний 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтийн тайланг хүргүүлж байна.

Хавсралт 10 хуудастай.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАНҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Л.БЯМБАСҮРЭН

УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАР ДАХЬ ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР
ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2024 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

Д/Д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
Зорилго 1 -Хүний эрхийг хамгаалах, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх чиглэлийн үйл ажиллагааг иргэд болон эмнэлгийн ажилтнуудад сурталчлах, соён гэгээрүүлэх					
1.	1.1.Хүний эрхийн Үндэсний Комисс болон Эрүүл мэндийн яамнаас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, гарын авлага зэргийг тухайн байгууллагын албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм youtube суаг). лед сурталчилгааны дэлгэц, самбарт байршуулах зараг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэх	Албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ лед сурталчилгааны самбарт байршуулсан сурталчилгааны тоо	-Баримтжуулсан байх -Үр дүнг тооцож тайлагнасан байх,(түгээсэн тоо, давтамж, авсан хандалтын тоо)	Эрүүл мэндийн яам болон Эрүүл мэндийн байгууллагууд	Хүний эрхийн Үндэсний комисс
Хүний эрхийн Үндэсний Комисс болон Эрүүл мэндийн яамнаас бэлтгэн боловсруулсан мэдээлэл түгээх контентүүдийг ашиглан Улсын Нэгдүгээр Төв Эмнэлгийн байгууллагын албан ёсны мэдээллийн сувгууд болох цахим фэйсбүүк фэйж хуудас, хамт олны групп, гадаад дотоод вэбсайтаа байршуулж хүний эрхийн тухай зөвлөмжүүдийг тогмол хугацаанд байршуулан ажилласан. Мөн хүний эрхийн холбоотой мэдээллүүдийг эмнэлгийн хүлээлгийн танхимын дэлгэц, ухаалаг самбаруудад байршуулан түгээн ажилласан.					



Зураг 1. Мэдээлэл байршуулсан явцаас

	1.3. Хүний эрхийг хамгаалах, зөрчихөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах "Хүний эрх" мэдээллийн самбар ажиллуулах;	Мэдээллийн самбарт байршуулсан тоо	-Мэдээллийг сар бүр шинэчлэх; -Тайланд сар бүр шинэчилсэн нотолгоог хавсаргасан байх.	Эрүүл мэндийн яам болон Эрүүл мэндийн байгууллагуу д	Хүний эрхийн Үндэсний комисс
--	---	------------------------------------	--	--	------------------------------

УНТЭ-ийн Захиргаа, Хүний нөөцийн алба нь эрүүл мэндийн салбарын ажилчидад “Ес зүйн” самбар ажиллуулдаг бөгөөд тус самбар нь хүний эрхийг хамгаалах, зөрчихөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг мэдээлэн сурталчилж ажилладаг.



Зураг 2. Ханын самбарт мэдээлэл байршуулсан явцаас

Зорилго 2- Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагааны онцлогт тохирсон мэдлэг, шинэ агуулга бүхий Хүний эрхийн сургалт зохион байгуулах, сургалтад хамруулах					
3.	2.1 Байгууллагын нийт ажилтнууд болон удирдах албан тушаалтнуудыг Хүний эрхийн сургалтад хамруулсан байх	Зохион байгуулсан сургалтын тоо	-Албан хаагчдыг холбогдох сургалтанд бүрэн хамруулсан байх -Тайланд нотолгоог хавсгарсан байх	Эрүүл мэндийн яам болон Эрүүл мэндийн байгууллагуу д	Хүний эрхийн Үндэсний комисс
2024.05.15-ны өдөр үндсэн мэргэжлийн суралцагч эмч нарын өглөөний яриан дээр Захиргаа, хүний нөөцийн албаны хүний нөөцийн менежер, УНТЭ-ийн дэргэдэх Ёсзүйн салбар хорооны нарийн бичгийн дарга О.Лхагвасүрэн “Хөдөлмөрийн тухай хууль”, “Байгууллагын хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ”, “Эмнэлгийн мэргэжилтний ёсзүйн дүрэм” сэдвээр сургалтыг амжилттай зохион байгуулсан					



Зураг 3. Сургалтын явцаас

4.	2.2 Байгууллагын нийт ажилтнууд болон удирдах албан тушаалтнуудыг ажлын байрны бэлгийн дарамтын талаарх сургалтад хамруулсан байх;	Зохион байгуулсан сургалтын тоо	Албан хаагчдыг холбогдох сургалтанд бүрэн хамруулсан байх -Тайланд нотолгоог хавсгарсан байх	Эрүүл мэндийн яам болон Эрүүл мэндийн байгууллагууд	Хүний эрхийн Үндэсний комисс
	Жендэрт суурилсан хүчирхийллийн (ЖСХ) эсрэг 16 хоногийн аян жил бүрийн 11-р сарын 25-наас 12-р сарын 10-ны хооронд тохиодог бөгөөд тус аяныг 2024 онд дэлхий нийтээр "Охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоход нэгдье" уриан дор зохион байгуулж байгаа бол Монгол Улсад "ОХИД ЭМЭГТЭЙЧҮҮД ХААНА Ч АЮУЛГҮЙ-Шалтаг бүү тооч" нэрийн дор зохион байгуулав. УНТЭ тус аянд нэгдэж, үйл ажиллагааны төлөвлөгөө гарган ажиллаж байна. НЭМА-ны дарга Г.Алтанцоо байгууллагын эмч, сувилагч, эмнэлгийн ажилтан нарт "Охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоход нэгдье" мэдээлэл хийж, хүчирхийллийн эсрэг аянд нэгдэхийг уриаллаа. Тус аяны үйл ажиллагааны хүрээнд УНТЭ-ийн Ерөнхий захирлын 2022 оны А/246 дугаар тушаал "Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, гарсан гомдлыг шийдвэрлэх журам" ажлын байрны бэлгийн дарамтын талаарх мэдлэг, ойлголтыг тандах урьдчилан сэргийлэх санал асуулгын хуудасны загвараар судалгаа авч судалгааны дүгнэлтэнд тулгуурлан арга хэмжээг зохион байгуулхаар төлөвлөн ажиллаж байна.				



Зураг 4. Сургалт, судалгааны явцаас

5.	2.3 Байгууллагын нийт ажилтнууд болон удирдах албан тушаалтнуудыг Хөдөлмөрийн харилцаан дахь хүний эрхийн асуудлаар сургалтад хамруулах	Зохихон байгуулсан сургалтын тоо	Албан хаагчдыг холбогдох сургалтанд бүрэн хамруулсан байх -Тайланд нотолгоог хавсгарсан байх	Эрүүл мэндийн яам болон Эрүүл мэндийн байгууллагууд	Хүний эрхийн Үндэсний комисс
----	---	----------------------------------	---	---	------------------------------

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газраас 2024 оны 08 сарын 23-ны өдөр зохион байгуулагдсан нуугдмал баялаг төслийн уулзалт, эерэг нөлөөллийн арга хэмжээ, хэлэлцүүлэгт НЭМА-ны дарга З.Ариунжаргал оролцсон бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэхэд тулгардаг асуудлын талаар байр сууриа илэрхийлж хамтран ажиллах хүсэлтэй байгаагаа илэрхийлж оролцсон.



Зураг 5. Уулзалт, хэлэлцүүлгийн явцаас

2024.09.13-ны өдөр Жендерийн үндэсний хороотой хамтран Хүний эрхийн боловсрол хариуцсан референт О.Тодбулаг “Хүний эрхийн ойлголт, хууль эрхзүй” сэдвээр дэмжих үйлчилгээний ажилтнуудад сургалтыг амжилттай зохион байгуулсан.



Зураг 6. Сургалтын явцаас

2024.03.01-2024.04.01-ний хугацаанд Засгийн газар, Жендерийн үндэсний хорооноос НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Монгол цэргийн өдрийг тохиолдуулан үндэсний хэмжээнд “Харилцан хүндэтгэж тэгш оролцоог хангая” уриатайгаар зохион байгуулсан “ХАРИЛЦАН ХҮНДЭТГЭЭ” нэг сарын аянд “Улсын Нэгдүгээр төв Эмнэлэг”-ийн хамт олон нэгдэж хамтарч ажилласан.



Зураг 7. Аяны уриа зураг

Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аяны нээлтийн үйл ажиллагаа 2024.11.22 өдөр Монгол Улсын Засгийн газар, Жендерийн үндэсний хорооноос НҮБ-ын Хүн Амын Сангийн дэмжлэгтэйгээр зохион байгуулж, “ОХИД ЭМЭГТЭЙЧҮҮД ХААНА Ч АЮУЛГҮЙ-Шалтаг бүү тооч” уриан дор аяныг үндэсний хэмжээнд албан ёсоор эхлүүлж нээлтэнд УНТЭ-ийн НЭМА-ны дарга Г.Алтанцоо, НЭМА-ны мэргэжилтэн Д.Гандулам нар оролцсон.



Зураг 8. Нээлтийн явцаас

2024.04.05-ны өдөр Эрүүгийн цагдаагийн албаны Кибер гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэсийн мөрдөн байцаагч, ахлах дэслэгч Т.Баясгалантай хамтран “Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд анхаарах асуудал” түүнээс урьдчилан сэргийлэхэд анхаарах асуудал” сэдвээр УНТЭ-ийн дэмжих үйлчилгээний 245 ажилтануудад сургалтыг амжилттай зохион байгууллаа.




Зураг 9. Сургалтын явцаас

2024.04.16-ны өдөр Эрүүгийн цагдаагийн албаны Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэсийн мөрдөн байцаагч н.Сугарганболдтой хамтран “Эрүүл мэндийн салбарт үйлдэгдэж буй гэмт хэрэг, түүнээс урьдчилан сэргийлэхэд анхаарах асуудал” сэдвээр УНТЭ-ийн нийт сувилагч, тусгай мэргэжилтэнгүүдэд /300/ сургалтыг амжилттай зохион байгууллаа.



Зураг 10 . Сургалтын явцаас

2024.05.22-ны өдөр Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх хэлтсийн комиссар Д.Балдандоржтой хамтран “Эрүүл мэндийн байгууллагад холбогдох асуудлууд, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх нь” сэдвээр УНТЭ-ийн нийт эмч, төв, тасгийн эрхлэгч нарт сургалтыг амжилттай зохион байгууллаа.



Зураг 11. Сургалтын явцаас

Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн дэргэдэх Эрдмийн сургуулийн Анагаах ухааны эрхзүй ба боловсрол судлалын тэнхимийн багш, хуульч, өмгөөлөгч Э.Ганбаттай хамтран “Мэргэжлийн ёс зүй ба анагаах ухааны эрхзүй” сэдэвт 1 кредитийн сургалтыг 2024.01.23-нд тус эмнэлгийн удирдах албан тушаалтан, тасгийн эрхлэгч, их эмч нарт амжилттай зохион байгууллаа.



Зураг 12. Сургалтын явцаас

Зорилго 3- Хүний эрхийн зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах

6.	3.1 Хүний эрхийн Үндэсний Комисс болон Эрүүл мэндийн арга яамнаас хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулж, зөрчил үүсэх болсон шалтгаан нөхцөлийг арилгасан байх;	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-Арга хэмжээ зохион байгуулсан байх - Тайланд нотолгоог хавсгарсан байх	Эрүүл мэндийн яам болон Эрүүл мэндийн байгууллагууд	Хүний эрхийн Үндэсний комисс
	УНТЭ нь Эмнэлгийн ерөнхий захирлын 2022 оны А/246 тоот тушаалын дагуу нийт ажилтнуудын “Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, гарсан гомдлыг шийдвэрлэх журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, ажлын байрны бэлгийн дарамттай холбоотой мэдээлэл, гомдол гаргах процессын зураглал, ажлын байрны бэлгийн дарамтын талаарх мэдлэг, ойлголтыг тандах урьдчилан сэргийлэх санал асуулгын хуудасны загвар, холбогдох сургалтын хөтөлбөрийн загвар, “Хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ” -нд ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх заалт тусгаж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.				

					
Зураг 13. Баталсан журам					
Зорилго 4- Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн хүний эрхийг хангахад чиглэсэн үйл ажиллагааг сайжруулах					
7.	4.2 Эмч ажилчдыг ажлын байрны стрессээс сэргийлэх, сэтгэцийн эрүүл мэндийг нь дэмжихэд чиглэсэн сургалтыг тогтмол зохион байгуулах	Зохион байгуулсан сургалтын тоо	-Эмч, ажилчдыг сургалтанд тогтмол хамруулсан байх - Тайланд нотолгоог хавсгарсан байх	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв	Эрүүл мэндийн яам
2024 онд сэтгэл зүйн зөвлөгөө, сэтгэл заслын үйлчилгээг нийт 312 хүн/давхардсан тоогоор/ үзүүлсэн байна. Ажилтан, түүний гэр бүл – 132 Сэтгэл зүйн зөвлөгөө, сэтгэл заслын тусламжинд • Проектив сэтгэл заслын зурган картууд • Персона /Хувь хүний сэтгэл зүйн байдал, тулгамдаж буй асуудал, харилцааны зөрчлийг илрүүлэх, сэтгэл засах/ • Персонита / Хувь хүний сэтгэл зүйн байдал, бага насны сэтгэл зүйн гэмтлийг илрүүлэх, сэтгэл засах/ • Инук / Бага насны сэтгэл зүйн гэмтлийг илрүүлэх, сэтгэл засах/ • Oh card/ Хувь хүний сэтгэл зүйн байдал, бага насны сэтгэл зүйн гэмтлийг илрүүлэх, сэтгэл засах/ • Амьдрахын тулд уучил /Уй гашуутай ажиллах, сэтгэл засах/ • EQ- /хүүхдийн сэтгэл хөдлөлтэй ажиллах/ картуудыг ашиглаж байна. 2024 оныг “Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан үйл ажиллагааны шинэчилсэн төлөвлөгөөндөө ажилтнуудын сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор “Шинэ сувилагч” арга хэмжээний хүрээнд “Ажлын байранд дасан зохицохуй” “Стресс менежмент” сэдвээр 3 удаа, Зүрх судасны тасаг болон Ариутгал халваргүйтгэлийн тасгийн хамт олонд “Ажлын					

байран дээрхи эерэг уур амьсгал” сэдвээр проектив зурган картын аргаар бүлгийн сэтгэл засал эмчилгээг 2 удаа, нийт ажилчдад “Сэтгэцийн эрүүл мэнд ба сэтгэл зүйн сайн сайхан байдал” “Стресс ба таргалалт” сэдвээр 2 удаа тус тус зохион байгуулсан. Мөн өөрөөс гаралтай тайвшруулах сэтгэл засал болон урлагийн сэтгэл заслын эмчилгээний аргууд болох чиглүүлэгт зурган засал, элсэн заслын аргуудыг нэвтрүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.



Зураг 14. Сэтгэл заслын аргуудаа танилцуулж мэдээлж буй байдал сургалтын явцаас

Тайлан хянасан: НЭМА-ны дарга

Тайлан боловсруулсан: НЭМА-ны мэргэжилтэн

Г.Алтанцоо

Д.Гандулам